



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 5/31

Хэрлэн сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Засгийн газрын 1997 оны "Аймаг нийслэлийн Засаг даргын олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2003 оны А/99 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн "Хүндэт тэмдэг" олгох журам, 2015 оны А/511 дүгээр захирамжаар батлагдсан "Хан Хэнтийн алдартан тэмдэг олгох журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Салбартаа тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж, аймаг орон нутгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан төрийн байгууллагын зарим албан хаагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг шагнасугай.

2. "Хан Хэнтийн алдартан" тэмдгээр шагнуулах хүмүүсийн нэрсийг нэгдүгээр, аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрсийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Жуух бичиг"-ийн зардалд шаардагдах 60,000 /жаран мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 597